



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/162

Зуунмод

Газрын хэмжээ, зориулалт
өөрчлөх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Газрын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмшиж байгаа газрынхаа зориулалт, хэмжээ өөрчлүүлэх хүсэлтээ ирүүлсэн “Төв-Чандмань” ДЭХГ (РД:385562)-ын хүсэлтийн дагуу Энхтайван (6-р) багийн 1131 тоот байршилтай гүний худгийн зориулалттай 899 м2 газрын хэмжээг 1565 м2 уурын зуухны зориулалттай болгон өөрчилж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч “Төв-Чандмань” ДЭХГ-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1.Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2.Газрын кадастрын зураглалыг хийлгэж, Мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4.Эзэмшиж байгаа газрынхаа эргэн тойронд (50-аас доошгүй метрийн)-ийн доторх хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, орчноо цэвэр ариун байлгах арга хэмжээ авах.

3.Газрын даамал (Г.Баярсайхан), БОХ-ын улсын байцаагч (Н.Шинэбаяр) нарт дараах ажил үүрэг болгосугай.


3.1.Газрын төлбөрийг хугацаанд нь төсөвт оруулах.

3.2.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн А/220 дугаар захирамжийн 8-рт байрлах “Төв-Чандмань” ДЭХГ-т холбогдох хэсэг, 000006570 тоот гэрчилгээг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.САРАНГЭРЭЛ



Zahiramj-2022-2
4122050608